



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар A/32

Улаанбаатар хот

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 1.4.6, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/346 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Сити тур” аяллын аудио хөтөч төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	Д.Ганболд	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Захиргааны хэлтсийн дарга
Гишүүд	Ц.Сэргэлэн	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн мэргэжилтэн
	А.Эрдэнэцогт.	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	Н.Энхбат	УБ хот, ЧД 2-р хороо, С.Чоймболын гудамж 55-64 тоотод оршин суугч иргэн /зөвшилцснөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Ербахыт	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг 2018 оны 05 дугаар сарын 15-ны дотор багтаан явуулахыг Үнэлгээний хорооны дарга /Д.Ганболд/-нд даалгасугай.

ДАРГА

Д.Ганболд

Д.БАТСҮХ

1150500105  
УОА0453 5284325

1150500105